



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 02

Ховд

Г Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх тухай Г

Ховд аймгийн ихэнх нутгаар 2018 оны 07 дугаар сарын 03-05-ны хооронд дуу цахилгаантай аадар бороо үргэлжилэн орсоны улмаас үер буух үеэр Жаргалант, Мянгад, Чандмань зэрэг сумдын хэмжээнд нийт 630 айл өрхийг нүүлгэн шилжүүлж, 22 хүн, 17 хүүхдийн амь нас, 1013 гаруй малыг авран хамгаалсан байна.

Түүнчлэн 2019 оны 7, 8 дугаар сард нийт нутгаар олон жилийн дундажийн орчим ба түүнээс дулаарч, үе үе дуу цахилгаантай усархаг бороо орох урьдчилсан төлөв мэдээг Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан.

Иймд учирч болзошгүй үер усны гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх зорилгоор ДААЛГАХ НЬ:

Нэг: Баруун бүсийн төв-Ховд аймгийн

Онцгой байдлын газрын дарга дэд хурандаа Б.Алтанбадралт

1.1 Цаг агаарын аюулт үзэгдэл, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэгийг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах.

1.2 Үерийн үед ажиллах хүн хүч, техник хэрэгсэлийг бэлтгэх, бэлэн байдлыг хангуулах.

1.3. Мэргэжлийн байгууллагатай хамтран аймгийн үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах хоолойд үзлэг шалгалт зохион байгуулж, холбогдох байгууллагуудад зөрчлийг яаралтай арилгах талаар албан бичиг гаргаж хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах.

Хоёр: Ховд хотын захирагч, Жаргалант сумын Засаг дарга /Ганданповрон/

2.1. Жаргалант сумын хэмжээнд 2019 оны 07 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд дуу цахилгаантай аадар бороо орсны улмаас Жаргалант сумын 12 багийн 610 айл өрх, 6 орон сууцны подволь, 12 аж ахуйн нэгж байгууллага үерийн усанд автаж ихээхэн хохирол учирсан.

Иймд дараах чиглэлээр даалгах нь:

2.2. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох, хүн хүч, техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллах.

2.3. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах.

2.4. Орон нутгийн онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл боломжоор хангах дэмжлэг үзүүлэх.

2.5. Жаргалант сумын үерийн хамгаалалтын даланд үзлэг шалгалт хийж шар усны болон уруйн үер усны улмаас эвдэрч болзошгүй газруудад даланг сэргээн засварлах.

2.6. Сум, орон нутгийн хэмжээнд үерийн аюулын эрсдэлийн үнэлгээ хийж, аюулын зураглал гаргах.

2.7. Үерийн урсгалын гольдрил, ховил, далан, суваг шуудууг хаасан хог хаягдалыг цэвэрлэх ажиллагааг шуурхай зохион байгуулах.

2.8. Үерийн эрсдэл бүхий газар буусан зөвшөөрөлгүй айл өрхийг албадан нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах.

2.9. Жаргалант сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд үерийн аюул, болон гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, харилцаа, холбоо, зарлан мэдээлэх системийн байнгын бэлэн байдлыг хангах.

Гурав:Сумдын Засаг дарга нарт:

3.1. Үерийн аюулын тухай Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан урьдчилан сэргийлэх мэдээ, гэнэтийн үерийн тухай ард иргэдийн дамжуулсан мэдээллийг хүлээн авч мэдээлэлд дүн шинжилгээ хийж үер усны аюулаас сэрэмжлүүлэх мэдээллийг байгууллага аж ахуйн нэгж, малчид, ард иргэдэд шуурхай хүргэж ажиллах.

3.2. Сум, орон нутгийн хэмжээнд үерийн аюулын эрсдэлийн үнэлгээ хийж, аюулын зураглал гаргаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах.

3.3. Үер усны аюул тохиолдсон үед сум байгууллага, аж ахуйн нэгж гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу ажиллаж, төрийн болон төрийн бус байгууллагууд, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангитай хамтран үерт өртөж болзошгүй айл өрхийг нүүлгэн шилжүүлэх.

3.4. Бага насны хүүхдийг хараа хяналтгүй голын эргээр явуулахгүй байх талаар гэр бүл, асран хамгаалагчдад зөвлөх, иргэдийн болгоомжгүй байдлаас усанд осолдож амь насаа алдахаас урьдчилан сэргийлэх.

3.5. Сум орон нутгийн үерийн хамгаалалтын даланд үзлэг шалгалт хийж шар усны болон уруйн үер усны улмаас эвдэрч болзошгүй газруудад даланг сэргээн засварлах.

3.6. Сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах үерийн усны аюулын үед хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар мөрдөж шуурхай ажиллагааг зохион байгуулж хохирлын үнэн зөв тооцох.

3.7. Үерийн аюул тохиолдсон үед сандарч тэвдэлгүйгээр өөрийн болон бусдын амь насыг хамгаалах, өрх бүр хөвөгч хэрэгсэлтэй болох, үерээс хамгаалах уламжлалт аргуудыг ард иргэдэд ухуулан таниулах, сургах.


3.8. Үерийн урсгалын гольдрил, ховил, далан, суваг шуудууг хаасан хог хаягдалыг цэвэрлэх ажиллагааг шуурхай зохион байгуулах.

3.9. Малчид ард иргэдэд хашаа, хороо, гэр орноо үерийн уснаас хамгаалсан далан, суваг, шуудуу татуулах арга хэмжээг зохион байгуулах.

Дөрөв: Ховд АЗЗА ХХК –ний захирал /Б.Батсүх/-д

4.1 Төв суурин газрын төвлөрсөн авто замыг үерээс хамгаалах далан суваг, шуудууг сэргээх, ус зайлуулах хоолойг цэвэрлэх, усны түрэлт үүсч болзошгүй газруудад даланг өндөрлөх зэрэг ажлыг зохион байгуулж, шаардлагатай хүн хүч, техникийн бэлэн байдлыг хангах.

Энэ албан даалгаварын биелэлтийг хангуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга дэд хурандаа Б.Алтанбадралтад даалгасугай.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

